



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/02

Мандалговь

Сумын Засаг даргын Тамгын
газрын бүтэц орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвин тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоол, 1994 оны 128 дугаар тогтоолын 7 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны цалингийн санд багтаан, албан хаагчдын эзэмшсэн мэргэжил, туршлагыг харгалзан бүтэц, орон тоог шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Бүтэц орон тоог шинэчилсэнтэй холбогдуулан албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн)-д даалгасугай.

3. Сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог шинээр батлахтай холбогдуулан 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн Б/03 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

4. Шинээр батлагдсан ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийн дагуу хариуцсан ажлаа хийж гүйцэтгэхийг төрийн албан хаагчдад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ

49120120 2

Сайнцагаан сумын Засаг даргын 2023
оны 01. сарын 02-ны өдрийн 1/02
дугаар захирамжийн хавсралт

№	Бүтэц	Албан тушаал	Албан тушаалын ангилал	Тоо
1	Удирдах	Засаг дарга	Улс төр	1
		Засаг даргын орлогч	Улс төр	1
		Тамгын газрын дарга	ТЗ	1
Нийт				3
2	Захирагчийн ажлын алба	Хот төлөвлөлт, хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн	ТЗ	1
		Хот тохижилт, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	ТЗ	1
Нийт				2
3	Гүйцэтгэх	Санхүүгийн албаны дарга	ТЗ	1
		Санхүүгийн албаны мэргэжилтэн	ТЗ	1
		Нийгмийн бодлогийн мэргэжилтэн	ТЗ	2
		Бэлчээр, тэжээл, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ	1
		Хүнс, ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ	1
		ХААТасгийн дарга, Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ	1
		Хууль, эрх зүй, худалдан авах ажиллагаа, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	ТЗ	1
		Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ	1
		Хүний нөөц, төлөвлөлт, судалгаа шинжилгээ, сургалт хариуцсан ажилтан	ТҮ	1
		Засаг даргын туслах, дотоод ажил хариуцсан ажилтан	ТҮ	1
Хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологийн ажилтан	ТҮ	1		
нийт				12
4	Баг	Багийн засаг дарга	Улс төр	9
		Багийн нийгмийн ажилтан	ТҮ	5
Нийт				14
5	Үйлчлэх	Үйлчилгээний нягтлан бодогч	ТҮ	1
		Тусгай сан хариуцсан нягтлан бодогч	ТҮ	1
		Нярав	ТҮ	1
		Архив, бичиг хэргийн ажилтан	ТҮ	1
		Жолооч	ТҮ	3
		Үйлчлэгч	ТҮ	2
Нийт				13
Дүн				44